



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 409

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 33 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд хийгдсэн нийт 249,068,450.00 (хоёр зуун дөчин есөн сая жаран найман мянга дөрвөн зуун тавин) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.“Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Батхуяг, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Баасанжаргал нар дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003063

2022.09.29 22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 09 дүгээр сарын-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийг
"Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэх
хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж, хүчин чадал	Тоо хэмжээ	Нийт дүн /төгрөг/
1	42-47 дугаар худгийн шугамын шинэчлэл	метр	130м /5хос/	43,338,088.00
2	Ус түгээх 8-р худаг барих ажил	ш	1	21,500,000.00
3	Гэр хорооллын Ойчдын 17-р гудамжинд төвлөрсөн ус хангамжийн шугам шинээр татах ажил	метр	1200	42,738,522.00
4	"Шинэ Орчин" 72 айлын орон сууцнаас 32 айлын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний /2-р ээлж/	метр	1458м /4 хос/	141,491,840.00
				249,068,450.00
Нийт дүн				(хоёр зуун дөчин есөн сая жаран найман мянга дөрвөн зуун тавин төгрөг)